

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэт-Ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК-ний 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2023/06/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn
Эрдэнэт хот

2023 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Аудитор: Б.Бямбатогтох
Утас: 70357955 Цахим хаяг: byambatogtokhb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2023.03.15 № 94
танай _____-ны № _____-т

ЭРДЭНЭТ УС, ДУЛААН ТҮГЭЭХ
СҮЛЖЭЭ ОНӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.БҮҮВЭЙБААТАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэт Ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК-ний 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрдэнэт Ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК-ний 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрдэнэт Ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК-ний ТУЗ-н 2022 оны 10 дугаар тогтоолоор 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тодотгон баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 22,399.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 22,778.4 сая төгрөгөөр, 378.7 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 1,058.6 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 24,591.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 24,895.9 сая төгрөгийн зардал гарган, 304.4 сая төгрөгийн татварын өмнөх алдагдалтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудал юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч

үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Тайлант онд нийт 3,789,075.4 м³ усыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас авч, 2,116,343.4 м³ усыг борлуулж, нийт авсан усны 55.85 хувийг борлуулж, 44.15 хувийн усыг орлого болоогүй усны өглөгөөр бүртгэж тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Эрдэнэт Ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК-ний 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилго, 20 зорилт, 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлийг дээд шатны захирагч 97 хувьтай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэгэн төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		Өмнөх он	Тайлант он
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,059,656,924.09	2,522,130,487.00
1.1.02	Дансны авлага	15,126,332,973.53	13,867,621,225.01
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	5,173,706.40	32,262,916.06
1.1.04	Бусад авлага	2,489,727.78	6,919,812.13
1.1.05	Бусад санхүүгийн хөрөнгө	570,323,078.32	2,870,365,528.40
1.1.06	Бараа материал	666,946,949.49	1,161,377,247.50
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	17,430,923,359.61	20,460,677,216.10
1.2.01	Үндсэн хөрөнгө	38,852,858,668.77	52,312,235,646.22
1.2.02	Биет бус хөрөнгө	136,404,386.62	123,530,164.62
1.2.08	Бусад эргэлтийн бус хөрөнгө	5,067,050,388.05	6,364,370,472.34
1.2.09	Газар / Биет бус хөрөнгө - Бусад /	2,465,395,000.00	2,480,362,800.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	46,521,708,443.44	61,280,499,083.18
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	63,952,631,803.05	81,741,176,299.28
2.1.1.01	Дансны өглөг	12,596,540,802.77	13,678,270,311.07
2.1.1.03	Татварын өр	59,470,727.43	0.00
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	432,699,527.04	764,562,619.84
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	38,806,847.94	49,855,316.24
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	13,127,517,905.18	14,492,688,247.15
2.1.2.05	Хойшлогдсон орлого	5,067,050,388.05	6,364,370,472.34
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	5,067,050,388.05	6,364,370,472.34
2.2	Өр төлбөрийн нийт дүн	18,194,568,293.23	20,857,058,719.49
2.3.01	Өмч: - төрийн	5,231,568,753.18	5,231,568,753.18
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,586,709,828.68	2,586,709,828.68
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	43,302,195,875.79	58,732,662,273.79
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-5,362,410,947.83	-5,666,823,275.86
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	-304,412,328.03
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-5,362,410,947.83	-5,362,410,947.83
2.3.11	Эздийн өмчийн дүн	45,758,063,509.82	60,884,117,579.79
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	63,952,631,803.05	81,741,176,299.28

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
01	Борлуулалтын орлого (цэвэр)	20,725,136,039.51	23,920,693,900.00
02	Борлуулалтын өртөг	12,714,363,973.51	14,819,055,787.28
03	Нийт ашиг(алдагдал)	8,010,772,066.00	9,101,638,112.72
04	Түрээсийн орлого	0.00	0.00
05	Хүүний орлого	0.00	0.00
06	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
07	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00

08	Бусад орлого	98,686,200.00	214,648,200.00
08.1	Орлогын дүн	98,686,200.00	214,648,200.00
09	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	8,106,916,693.19	10,014,633,723.64
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	0.00	0.00
12.1	Зардлын дүн	8,106,916,693.19	10,014,633,723.64
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-1,288,106.26	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	1,105,022.45	393,935,082.89
17.1	Олз, гарзын дүн	-183,083.81	393,935,082.89
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	2,358,489.00	-304,412,328.03
19	Орлогын татварын зардал	781,449.49	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	1,577,039.51	-304,412,328.03
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,577,039.51	-304,412,328.03
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	0.00	0.00
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	22,325,004,650.47	28,660,671,686.62
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	21,903,528,039.52	27,760,353,962.45
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	300,000,000.00	300,000,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	121,476,610.95	600,317,724.17
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	21,505,515,902.25	26,770,093,427.61
1.2.1	Ажиллагчдад төлсөн	3,301,607,931.88	4,102,227,313.01
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	964,200,000.00	1,235,221,060.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,128,040,086.78	1,640,361,921.70
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	362,923,362.02	472,657,970.48
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн	96,000,000.00	255,780,885.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	842,756,548.66	1,797,141,489.24
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	2,199,280.00	5,150,870.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	14,807,788,692.91	17,261,551,918.18

1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	819,488,748.22	1,890,578,259.01
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	148,531,835.00	428,104,696.10
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	148,531,835.00	428,104,696.10
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-148,531,835.00	-428,104,696.10
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	670,956,913.22	1,462,473,562.91
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	388,700,010.87	1,059,656,924.09
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,059,656,924.09	2,522,130,487.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2020 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	5,231,568,753.18	2,588,875,182.68	39,250,136,404.16	5,366,153,341.34	41,704,426,998.68
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00
03	Залруулсан үлдэгдэл	0.00	-2,165,354.00	0.00	2,165,354.00	0.00
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	1,577,039.51	1,577,039.51
05	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
06	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	4,052,059,471.63	0.00	4,052,059,471.63
07	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
09	2021 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	5,231,568,753.18	2,586,709,828.68	43,302,195,875.79	5,362,410,947.83	45,758,063,509.82
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00
11	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-304,412,328.03	-304,412,328.03
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	15,430,466,398.00	0.00	15,430,466,398.00
15	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00

16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
17	2022 оны 12 сарын 31-р үлдэгдэл	5,231,568,753.18	2,586,709,828.68	58,732,662,273.79	5,666,823,275.86	60,884,117,579.79

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021 оны гүйцэтгэл	2022 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт (хувиар)
1. Ажил үйлчилгээ, бүтээгдэхүүн буюу техникийн үзүүлэлт							
1.1	Цахилгаан эрчим хүчээр хангах хэрэглэгчид	Айл өрх	8403	8403	9498	(1095)	113.0
		ААНБ	633	633	812	(179)	128.3
1.2	Дулаанаар хангах хэрэглэгчид	Айл өрх	14130	14382	14382	0	100.0
		ААНБ	1318	1200	1325	(125)	110.4
1.3	Цэвэр усаархангах, бохир усыг татан зайлуулах үйлчилгээ үзүүлэх хэрэглэгчид	Айл өрх	12394	12394	14321	(1927)	115.5
		ААНБ	1384	1384	1474	(90)	106.5
1.4	Ус түгээх байр	ширхэг	84	84	93	(9)	110.7
1.5	Ажиллагсад	хүн	311	316	314	2	99.4
1.6	Дундаж цалин	Мян.төг	1,037,037.7	1,274,494.0	1,273,614.0	880	99.9
2. Орлого, зардал, ашгийн буюу эдийн засгийн үзүүлэлт							
2.1	Нийт орлого	Мян.төг	20,858,397.5	22,399,710.6	24,591,524.0	(2,191,813.4)	109.8
2.1.1	Цахилгаан	Мян.төг	6,175,494.6	6,141,850.7	7,083,528.3	(941,677.6)	115.3
2.1.2	Дулаан	Мян.төг	7,449,134.9	7,879,328.6	8,335,449.9	(456,121.3)	105.8
2.1.3	Цэвэр ус хангамж	Мян.төг	3,504,257.6	4,149,857.9	4,475,697.8	(325,839.9)	107.9
2.1.4	Ариутгах татуурга	Мян.төг	2,522,442.7	3,032,985.1	3,297,920.4	(264,935.3)	108.7
2.1.5	Цахилгаан шат	Мян.төг	115,265.8	159,967.9	174,712.0	(14,744.1)	109.2
2.1.6	ӨЭУУ хангамж	Мян.төг	843,934.7	824,438.6	946,801.9	(122,363.3)	114.8
2.1.7	Тоолуурын хэсэг	Мян.төг	29,203.9	51,651.4	62,765.5	(11,114.1)	121.5
2.1.8	Бусад	Мян.төг	218,663.3	159,630.4	214,648.2	(55,017.8)	134.5
2.2	Нийт зардал	Мян.төг	20,856,820.5	22,778,426.2	24,895,936.3	(2,117,510.1)	2,057.1
2.2.1	Үндсэн ба нэмэгдэл цалин	Мян.төг	3,870,225.0	4,817,587.3	4,798,978.1	18,609.2	99.6
2.2.2	Ажил олгогчоос төлөх НДШ	Мян.төг	545,819.9	650,374.3	651,867.4	(1,493.1)	100.2

2.2.3	Цахилгаан	Мян.төг	741,237.7	797,018.4	814,477.1	(17,458.7)	102.2
2.2.4	Дулаан	Мян.төг	20,413.6	21,790.3	20,036.6	1,753.7	92.0
2.2.5	Ус	Мян.төг	34,175.3	29,568.6	44,976.6	(15,408.0)	152.1
2.2.6	Урсгал засвар, сэлбэг	Мян.төг	283,459.2	438,965.0	452,863.8	(13,898.8)	103.2
2.2.7	Түлш шатахуун	Мян.төг	132,206.4	210,490.2	186,019.9	24,470.3	88.4
2.2.8	Албан томилолт	Мян.төг	1,623.3	5,628.0	4,480.3	1,147.7	79.6
2.2.9	Бичиг хэрэг	Мян.төг	18,123.5	30,740.9	29,674.9	1,066.0	96.5
2.2.10	Холбоо	Мян.төг	25,968.5	34,544.5	27,820.3	6,724.2	80.5
2.2.11	Хөдөлмөр хамгаалал	Мян.төг	168,761.2	197,324.0	181,788.2	15,535.8	92.1
2.2.12	Элэгдэл	Мян.төг	1,806,691.0	2,096,167.3	2,374,178.1	(278,010.8)	113.3
2.2.13	Зар сурталчилгаа	Мян.төг	4,325.9	11,000.0	10,887.1	112.9	99.0
2.2.14	Нийгмийн халамж	Мян.төг	129,506.8	151,793.2	199,916.0	(48,122.8)	131.7
2.2.15	ТЗЭ-ийн зохицуулалтийн хөлс	Мян.төг	81,725.3	41,525.2	47,173.6	(5,648.4)	113.6
2.2.16	Татвар, даатгалын зардал	Мян.төг	32,990.7	34,230.9	29,661.8	4,569.1	86.7
2.2.17	Гаднын үйлчилгээний хөлс	Мян.төг	36,995.7	51,768.9	40,394.3	11,374.6	78.0
2.2.18	Бусад үндсэн үйл ажиллагаа	Мян.төг	172,667.7	86,819.2	99,439.6	(12,620.4)	114.5
2.2.19	Худалдан авсан эрчим хүч	Мян.төг	12,714,364.0	13,019,269.9	14,819,055.8	(1,799,785.9)	113.8
2.2.20	Үйл ажиллагааны бус зардал	Мян.төг	35,539.8	51,820.1	62,246.8	(10,426.7)	120.1
2.2.21	Орлого болоогүй усны төлбөр	Мян.төг	-	-	-	-	-
2.3	Ашиг, алдагдал	Мян.төг	1,577.0	(378,715.6)	(304,412.3)	(74,303.3)	(1,947.4)

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 373.8 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 10.2 сая төгрөгийн алдааг залруулж, 363.6 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Үүнд: Хөдөлмөрийн чадвар алдалттай ажиллагсдын цалингаас 10.2 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутган тооцсоныг санхүүгийн тайланд татварын байгууллагаас авах авлага, хувь хүнд өгөх өглөгөөр бүртгүүлж аудитын явцад залруулж тайлагнууллаа.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар нийт 363.6 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 2.5 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 320.9 сая төгрөгийн 7 албан шаардлага хүргүүлж, 40.2 сая төгрөгийн 7 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

1. Хөдөлмөрийн чадвар алдалтын сунгалт хийгдээгүй 2 ажилтны 2,417.9 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг зөрүүтэй тооцоолж, тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2-д "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:", 20.2.7-д "аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах;", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1-д "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх," гэж заасантай нийцэхгүй байна.

2. 1 ажилтны гар утасны төлбөр болох 56.4 мянган төгрөгийг байгууллагаас төлсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.1-д "гар утасны зардал" гэж заасантай нийцэхгүй байна.

3.2 Албан шаардлага

1. Шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарт багтаан гэрэлтүүлгийн толгойг 10 удаагийн шууд худалдан авалт хийсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Албан шаардлага хүргүүлэв.

2. Бизнес төлөвлөгөөнд тусаагүй 37,082.9 мянган төгрөгийн 183 нэр төрлийн материалыг худалдан авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Албан шаардлага хүргүүлэв.

3. Биет ба биет бус хөрөнгөд бүртгэлтэй 6,000.0 мянган төгрөгийн хүний нөөцийн программ биетээр байхгүй, 400.0 мянган төгрөгийн архив албан хэрэг хөтлөлтийн программ ашигладаггүй байхад үндсэн хөрөнгийн тооллогын комисс дутагдлаар тоолоогүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.4-д "Тооллогын комисс дараах үүрэгтэй", 72.4.1-д "эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах", 72.4.2-д

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

"тоолсон эд хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн үнийн жишигтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих", 72.4.5-д "эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон тухайн үеийн зах зээлийн үнийн жишгээс хэт өндөр үнээр авсан, хэт доогуур үнээр борлуулсан үндсэн хөрөнгө, түүхий эд, бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг илрүүлж гэм буруутай хүмүүсээр төлүүлэх буюу данснаас хасуулах тухай саналаа тавих" гэж заасантай нийцэхгүй байна.

Албан шаардлага хүргүүлэв.

4. Тайлант онд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй 267 нэр төрлийн 115,375.2 мянган төгрөгийн бараа материал, эхний үлдэгдэлтэй байхад дахин худалдан авалт хийсэн 22 нэр төрлийн 3,569.0 мянган төгрөгийн бараа материал байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасантай нийцэхгүй байна.

Албан шаардлага хүргүүлэв.

5. Хөдөлмөрийн чадвар алдалттай ажиллагсдын цалингаас 10,189.5 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутган тооцсон байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22.1-д "Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө:", 22.1.2-д "хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого;", 25.3-д "Суутган төлөгч нь хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлогод албан татвар ногдуулахад холбогдох нотлох баримтыг үндэслэн энэ хуулийн 22.1.2-т заасан чөлөөлөлтийг хасаж тооцно" гэж заасантай нийцэхгүй байна.

Албан шаардлага хүргүүлэв.

6. Хөдөлмөрийн тухай хуулийг хэвлүүлэхэд 3,000,000 төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.3-д "хэвлэлийн захиалгын төлбөр" гэж заасантай нийцэхгүй байна.

Албан шаардлага хүргүүлэв.

7. Байгууллагын үйл ажиллагааг сурталчлахаар 2 аж ахуй нэгжээр нэвтрүүлэг, нийтлэл бэлтгүүлж цахим сайтад байршуулахаар 9,000,000 төгрөгийн гэрээ байгуулж, төсвийг хэмнэлттэй төлөвлөж, зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.4-д "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Албан шаардлага хүргүүлэв.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цагийн бүртгэлийн программаас цагийн бүртгэлийг хэвлэх боломжгүй, хүний нөөцийн мэргэжилтэн эксэлээр цагийн бүртгэлээ гаргадаг байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цагийн бүртгэлийн программд хөгжүүлэлт хийж, программаас гарсан бүртгэлийг хүний нөөцийн мэргэжилтэн дахин хянаж, цагийн бүртгэлийг үнэн зөв бүртгэж байх.

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Эргэлтийн хөрөнгийг жилд 1 удаа захирлын тушаалаар тооллогын комисс тоолдог байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2-д "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана", 70.2.2-д "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эргэлтийн хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр хийж байх.

3. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөт хяналтаар илэрсэн бараа материалын тайланд бүртгэлгүй, агуулахад байсан 3,354.5 мянган төгрөгийн 27 нэр төрлийн илүү бараа материалыг орлогод бүртгээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.1-д "Үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн тооллогоор бэлэн байгаа үлдэгдэл, нягтлан бодох бүртгэлээр байвал зохих үлдэгдлийн хоорондын зөрүүг дор дурдсан журмаар тохируулан тооцно", 73.1.3-д "нэр төрлийн материал үнэ бүхий зүйлийн дутагдлыг бусад үнэ бүхий зүйлийн илүүдлээр нэг эд хариуцагчаас гарсан дутагдлыг нөгөө эд хариуцагч дээр гарсан илүүдлээр, хоёр өөр хугацаанд гарсан нэг төрлийн адил үнэтэй зүйлийн дутагдлыг илүүдлээр хаахыг хориглоно. Харин тооллогоор илэрсэн илүүдлийг зохих дансанд орлого болгож илүүдэл гарсан шалтгааныг тогтооно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дотоод хяналтын тооллогоор илэрсэн илүүдэл материалын үнийг дахин тооцоолж, бараа материалын зохих дансанд бүртгэх.

4. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд 6,290.7 мянган төгрөгийн бичиг хэргийн материалыг шууд зарлагаар бүртгэсэн, санхүүгийн тайланг аккрузал сууриар хөтлөөгүй байна. Энэ нь

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайлан бэлтгэхдээ акруэл сууриар хөтөлж байх.

5. Хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийг шинэчлээгүй, тооллогын комисс эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлээр хөрөнгийг тулгаж тоолоогүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.4-д "Тооллогын комисс дараах үүрэгтэй", 72.4.1-д "эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-н 10-д "Ажилчин, албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэл /НХМаягт БМ-10/ Аж ахуйн нэгж, байгууллагын ажилчин, албан хаагчдын албан хэрэгцээнд эзэмшиж байгаа эд хөрөнгийг нэр төрлөөр ангилан бүртгэж, уг бүртгэлийг тооллогын комисс 3 хувь үйлдэж, 1 дүгээр хувийг санхүүгийн албанд, 2 дугаар хувийг аж ахуйн эрхлэгч (нярав)-д, үлдэх хувийг эд хариуцагчид өгнө. Ажилчин, албан хаагчдын хэрэгцээнд ашиглагдаж байгаа эд хөрөнгийн бэлэн байгаа үлдэгдлийг тооллогын комисс үзэж биечлэн тоолоод тооллого явуулсан хугацааг тодорхой заан тооллогын бүртгэлд гарын үсэг зурна" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийг шинэчилж, тооллогын комисс эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлээр хөрөнгийг тулгаж тоолж байх.

6. Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цалингийн урьдчилгаанд олгосон 1,075.2 мянган төгрөгийг суутгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална:", 5.1.4-д "үнэн зөв байх;", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалингийн урьдчилгаанд олгосон 1,075.2 мянган төгрөгийн авлагыг барагдуулах.

7. Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Өмнөх оноос татварын болон бусад авлага 29,456.7 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлагыг бууруулж ажиллах.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эрдэнэт-Ус ДТС ОНӨХК	1	10.2		10.2			1	10.2				
Дүн	1	10.2		10.2			1	10.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалт-ны тоо	Тоо	Дүн
Эрдэнэт-Ус ДТС ОНӨХК	13	351.5	1	2.4	5	308.9	7	40.2				
Дүн	13	351.5	1	2.4	5	308.9	7	40.2				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Эрдэнэт-Ус ДТС ОНӨХК										
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Эрдэнэт-Ус ДТС ОНӨХК	3	12.05	1	0.05	2	12.0				
Дүн	3	12.05	1	0.05	2	12.0				

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ОНӨГ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			